



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 3 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 3 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28%-иар буюу 860 сая ам.доллараар буурч 2,197 сая ам.доллар байв. Үүнд экспорт 42%-иар буюу 736 сая ам.доллараар, импорт 10%-иар буюу 124 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 612 сая ам.доллараар буурч 126 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 3 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	2,613	3,057	2,197	445	17%	(860)	-28%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	1,482	1,772	1,036	289	20%	(736)	-42%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	1,130	1,286	1,162	155	14%	(124)	-10%
Тэнцэл	1,865	1,137	1,492	(728)		356	31%	352	486	(126)	134	38%	(612)	-126%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 558 сая ам.доллараар буурч 29 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 56% буюу 1,237 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 18% буюу 401 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 6%-иар өссөн бол БНХАУ-тай хийсэн худалдаа 34%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 23%-иар буурсан бол өмнөх сараас 2%-иар өсч 1.693-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс муудахад зэсийн болон чулуун нүүрсний үнийн индекс буурснаар тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас сайжрахад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын үнэ буурснаас голлон шалтгаалжээ.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2020 оны эхний 3 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 42%-иар букуу 736 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 39 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурсан бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.3 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		1,374	93%	1,663	94%		965	93%		289	21%	19%	(698)	-42%	-39%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	338	463	31%	361	504	28%	307	351	34%	41	9%	3%	(153)	-30%	-9%
1.2. Чулуун нүүрс	6,613	509	34%	7,733	642	36%	3,122	252	24%	132	26%	9%	(389)	-61%	-22%
1.3. Боловсруулаагүй нефть	1,631	101	7%	1,621	88	5%	322	18	2%	(13)	-13%	-1%	(70)	-80%	-4%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	1,441	64	4%	2,072	107	6%	2,062	141	14%	43	67%	3%	35	32%	2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	2,950	124	8%	4,665	196	11%	1,556	80	8%	72	58%	5%	(116)	-59%	-7%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	33	60	4%	44	63	4%	37	48	5%	2	4%	0%	(14)	-23%	-1%
1.7. Жонош, лейцит, нефелинт	78	25	2%	111	41	2%	137	35	3%	16	62%	1%	(5)	-13%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	10	1%	1	12	1%	2	11	1%	2	18%	0%	(1)	-6%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	1	0%	0	0	0%	(0)	-21%	0%	(1)	-94%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	-	0%	13	9	1%	(0)	0%	0%	9	0%	1%
1.11. Бусад	164	16	1%	75	12	1%	25	18	2%	(5)	-30%	0%	7	59%	0%
2. Мал аж, ахуй	123	42	3%	111	43	2%	82	28	3%	1	3%	0%	(15)	-35%	-1%
2.1. Амьд мал, малын мах	6	14	1%	7	14	1%	1	2	0%	(0)	-2%	0%	(12)	-86%	-1%
2.2. Арьс, шир	112	6	0%	98	4	0%	78	4	0%	(2)	-30%	0%	(0)	-9%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	2	0%	0	2	0%	0	2	0%	1	45%	0%	(0)	-9%	0%
2.4. Ноолуур	2	17	1%	2	15	1%	2	17	2%	(1)	-8%	0%	2	12%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	2	3	0%	3	7	0%	2	2	0%	4	130%	0%	(5)	-68%	0%
2.6. Бусад	0	0	0%	1	0	0%	0	0	0%	0	41%	0%	(0)	-76%	0%
3. Газар тариалан	2	1	0%	13	3	0%	9	3	0%	2	263%	0%	0	9%	0%
4. Аж үйлдвэрлэл	51	66	4%	118	62	4%	47	39	4%	(3)	-5%	0%	(23)	-37%	-1%
4.1. Хүнс	6	20	1%	7	18	1%	2	5	1%	(2)	-10%	0%	(13)	-72%	-1%
4.2. Ноолууран эдлэл	0	4	0%	0	8	0%	0	4	0%	4	79%	0%	(4)	-55%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	3	0%	1	2	0%	1	3	0%	(1)	-23%	0%	0	16%	0%
4.4. Уул уурхай	8	27	2%	36	27	2%	6	20	2%	(0)	-1%	0%	(7)	-27%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	19%	0%	(0)	-22%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	9	1%	0	5	0%	1	7	1%	(4)	-43%	0%	2	30%	0%
4.7. Бусад	35	1	0%	74	1	0%	38	1	0%	(0)	-4%	0%	(0)	-10%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-30%	0%	0	55%	0%
Нийт дүн		1,482		1,772			1,036			289	20%		(736)	-42%	

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)


Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 3 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(668)		(30)		(698)	-42%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(63)	41%	(90)	59%	(153)	-30%
1.2. Чулуун нүүрс	(373)	96%	(16)	4%	(389)	-61%
1.3. Боловсруулаагүй нефть	(71)	102%	1	-2%	(70)	-80%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(1)	-2%	35	102%	35	32%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(130)	113%	14	-13%	(116)	-59%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(9)	65%	(5)	35%	(14)	-23%
1.7. Жонош, лейцит, нефелинт	7	-129%	(12)	229%	(5)	-13%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	-146%	(2)	246%	(1)	-6%
1.11. Бусад	(38)	-553%	45	653%	7	59%
2. Мал аж, ахуй	(26)	172%	11	-72%	(15)	-35%
2.1. Амьд мал, малын мах	(23)	194%	11	-94%	(12)	-86%
2.2. Арьс, шир	(1)	277%	1	-177%	(0)	-9%
2.4. Ноолуур	0	18%	2	82%	2	12%
3. Газар тариалан	(2)	-614%	2	714%	0	9%
4. Аж үйлдвэрлэл	(123)	530%	99	-430%	(23)	-37%
5. Бусад	0	38%	0	16%	0	55%
Нийт дүн	(819)		83		(736)	-42%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах томооцоолол болохыг анхаарна уу.

2020 оны эхний 3 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 819 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 83 сая ам.доллараар өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 436 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 106 сая ам.доллараар тус тус буурав. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалж 123 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 99 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 3 дугаар сард 1,593 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 22%-иар өссөн бол өмнөх сараас 0.2%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,183; 89 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 20%-иар буурсан бол төмрийн хүдэр 3%-иар өссөн, зэсийн үнэ өмнөх сараас 9%-иар буурсан, харин төмрийн хүдэр 2%-иар өслөө. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 3 дугаар сард 69 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 17%-иар, өмнөх сараас 4%-иар буурлаа.

Импорт 2020 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10%-иар буюу 124 сая ам.доллараар буурав. Импортын 10 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 2 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		322	28%		351	27%		320	28%	29	9%	3%	(32)	-9%	-2%
Түргэн эдэлгээтэй	205	175	15%	179	170	13%	219	178	15%	(5)	-3%	0%	8	4%	1%
Хүнс	97	123	11%	84	120	9%	93	122	10%	(3)	-2%	0%	1	1%	0%
Эм, тариа	0	22	2%	1	20	2%	1	24	2%	(2)	-9%	0%	4	20%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	107	30	3%	94	30	2%	125	32	3%	0	1%	0%	2	7%	0%
Удаан эдэлгээтэй	30	147	13%	67	181	14%	53	142	12%	34	23%	3%	(39)	-22%	-3%
Гутал, хувцас, цүнх	11	15	1%	16	14	1%	23	15	1%	(2)	-11%	0%	2	12%	0%
Гэр ахуйн цах. хэрэгсэл ба тавилга	9	24	2%	37	23	2%	13	22	2%	(0)	-2%	0%	(1)	-4%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	91	8%	0	126	10%	0	86	7%	35	39%	3%	(40)	-32%	-3%
Бусад удаан эдэлгээтэй бараа	10	17	2%	13	18	1%	16	18	2%	1	7%	0%	(0)	-1%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	377	400	35%	300	519	40%	302	456	39%	119	30%	11%	(63)	-12%	-5%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	4	256	23%	6	375	29%	6	318	27%	119	46%	10%	(56)	-15%	-4%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	75	7%	1	125	10%	2	106	9%	50	67%	4%	(19)	-15%	-1%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	4	181	16%	5	249	19%	5	212	18%	68	38%	6%	(37)	-15%	-3%
Барилгын материал	93	93	8%	138	104	8%	138	97	8%	11	12%	1%	(7)	-6%	-1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	7	51	5%	5	41	3%	5	41	3%	(11)	-21%	-1%	(0)	0%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	345	176	16%	439	147	11%	375	146	13%	(29)	-16%	-3%	(1)	-1%	0%
Хүнсний орц	126	39	3%	8	4	0%	28	9	1%	(35)	-89%	-3%	5	105%	0%
Химийн бүтээгдэхүүн	43	24	2%	48	24	2%	45	23	2%	0	1%	0%	(1)	-4%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	13	5	0%	19	7	1%	21	7	1%	2	30%	0%	(0)	-7%	0%
Цахилгаан эрчим хүч	0	36	3%	0	37	3%	0	38	3%	1	3%	0%	1	2%	0%
Металлын хүдэр, баямал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-29%	0%	(0)	-24%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	193	71	6%	226	74	6%	207	69	6%	3	5%	0%	(5)	-6%	0%
Нефтийн бүтээгдэхүүн	345	231	20%	439	267	21%	375	239	21%	36	16%	3%	(28)	-11%	-2%
Дизель түлш	207	134	12%	263	163	13%	200	125	11%	29	22%	3%	(38)	-23%	-3%
АИ-92, АИ-95	79	55	5%	126	69	5%	102	63	5%	14	26%	1%	(6)	-8%	0%
А-80 болон бусад	59	42	4%	50	35	3%	72	50	4%	(7)	-18%	-1%	15	43%	1%
Бусад	6	2	0%	2	2	0%	60	1	0%	(1)	-29%	0%	(0)	-7%	0%
Нийт дүн		1,130		1,286			1,162			155	14%		(124)	-10%	

²% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 3 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	(10)	%	(22)	%	(32)	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(10)	30%	(22)	70%	(32)	-9%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	23	-37%	(86)	137%	(63)	-12%
Аж үйлдвэрлэлийн орц	1		(2)		(1)	-1%
Нефтийн бүтээгдэхүүн	(39)	136%	10	-36%	(28)	-11%
Дизель түлш	(39)	105%	2	-5%	(38)	-23%
АИ-92, АИ-95	(15)	267%	9	-167%	(6)	-8%
А-80 болон бусад	16	105%	(1)	-5%	15	43%
Бусад	1		(1)		(0)	-7%
Нийт дүн	(23)	19%	(101)	81%	(124)	-10%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 63 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 32 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 28 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 1 сая ам.доллараар тус тус буурснаар нийт импорт 124 сая ам.доллараар буурлаа.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1 хувиар, өмнөх сараас 6 хувиар тус тус буурч тонн тутамд 609 ам.долларт хүрэв.